

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№19/496

ШУС, НУС

2018

МЭДЭЭЛЛИЙН САЙТЫН МУЛЬТИМЕДИА ХЭРЭГЛЭЭНИЙ АСУУДАЛД

Б.Түвшинтөр*

*ХИС-ийн Сэтгүүл зүй, медиа технологийн тэнхимийн эрхлэгч, МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

Түлхүүр үг: тэмдэгтийн өргөн зурвас, мультимедиа, мэдээллийн сайт, Монголын мэдээллийн сайтууд, видео.

Удиртгал. Харилцаанд дүрс тэмдэгт, бичиг үсэг үүсэн, мэдээллийг хадгалж, боловсруулан, дамжуулж цаг хугацаа орон зайг ялсан байгалийн бус эл хөгжлийн нэгэн гол хөшүүрэг нь мэдээллийн хэрэглээний хялбар байдал юм. Сэтгүүл зүй үүсэх урьдач нөхцөл хийгээд цаашид хөгжих шат бүр тухайн үеийн мэдээлэл харилцааны технологийн дэвшилттэй нягт уялдаж ирсэн билээ.

Өдгөө мэдээлэл харилцааны технологийн хөгжил урьд хожид байгаагүйгээр хурдасч, үүнийг дагаад олон нийтийн мэдээллийн хэрэглээний зан төлөвт гарах өөрчлөлт ч мэдэгдэхүйц байна. Дэлхий дахинд өнгөрсөн нэг жилийн хугацаанд л гэхэд интернет орчинд нэвтрэх боломжтой хүний тоо 7%-иар өсч дөрвөн тэр бум давжээ, мөн нийгмийн сүлжээг идэвхитэй хэрэглэгчийн тоо 13%-иар өсч гурван тэрбум 200 саяд хүрсэн¹ нь судлаачдын тооцоолж байснаас хавьгүй хурдтай өсөлт юм.

Ийнхүү мэдээлэл харилцааны технологийн хөгжил, боломж хэн бүхэнд үг хэлэх, хэвлэн нийтлэх эрхийг мөн хэзээ хэзээнээс илүү олгож байгаа

ч сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын өмнө томоохон сорилыг тулгаж байна. Энэ нь нэг талаар мэдээллийн хэрэглэгчдийн анхаарал төвлөрөх хугацаа улам ахар болж, хэт уйдаамтгай, “хойрго” зан төлөв ноёлж буй явдал юм.

Иймд мэдээллийг уламжлалт байдлаар дан эх бичвэр эсвэл дан дуу, дүрсээр хүлээн авахаас илүүтэй дээрх тэмдэгтүүдийн нийлбэр, цогц байдлаар мөн дээр нь тухайн мэдээллээс урган гарах асуулт нэг бүрт хариулт болох холбоост чанартай хүлээн авахыг хэрэглэгчид эрхэмлэх болов. Энэ талаар судлаач Б.Болд-Эрдэнэ “Олон тэмдэгтийн өргөн зурвас буюу мультимедиа хэмээх интернет сэтгүүл зүйн ойлголт нь өнгөрсөн зууны 90-ээд оноос хэрэгсэл хоорондын нэгдэлшил буюу агуулга, мэдээллийг нэгэн горим бүхий тэмдэгтийн тогтолцоонд байршуулах технологийн боломж, бодит нөхцөл бүрдэснээр бий болсон юм.”² гэсэн бол Томас Л.Фрийдман “Дэлхий хавтгай” бүтээлдээ “Интернет амилахын хэрээр хүмүүс интернетэд илүү их зүйлийг хийхийг хүсэх болов. Тиймээс тэд илүү компьютерийг, програм хангамжийг, үг, хөгжим, зураг, датаг хялбархан дамжуулах мэдээлэл холбооны сүлжээг шаардах болжээ.”³

гэсэн нь ч бий. Тэгвэл Монголын мэдээллийн сайтууд хэрэглэгчдийнхээ мэдээлэл хүлээн авах зан төлөв, эрэлт хэрэгцээнд нийцсэн контент үйлдвэрлэж чадаж байна уу? Энэ талаар судлаач Б.Болд-Эрдэнэ “Монголын мэдээллийн сайтын хувьд бичвэр зонхилсон, сонин сэтгүүлийн цахим хувилбар төдий хавсарга нэмэлт өгөгдөл үгүй, байсан ч ач холбогдол, үнэ цэнэ багатай байгаа нь интернет сэтгүүлзүйн гол давуу тал болох мультимедиа чанар буюу технологийн боломжийг бүрэн дүүрэн нэгтгэсэн тэмдэгтийн орчныг буй болгож чадахгүй байна гэсэн үг”⁴ хэмээн дүгнэсэн байдаг.

Уламжлалт хэрэгслүүдийн хэрэглэгчид, тэр дундаа тогтмол хэвлэлийн хэрэглэгчдийн тодорхой хувь нь мэдээллийн сайтыг гол эх сурвалжаа болгож буй хандлага түгээмэл болоод багагүй хугацаа өнгөрчээ.

Дээрх асуултад бага ч болов хариулт олох зорилготой бичил судалгааг Монголын мэдээллийн тэргүүлэх сайтуудын тодорхой хугацааны мэдээ, мэдээллийг сонгож, Дэлхийд тэргүүлэх мэдээллийн сайтуудын мөн хугацаанд бэлтгэн эргэлтэнд оруулсан мэдээ, мэдээлэлтэй харьцуулан судаллаа.

Судлагаанд тоон болон чанарын шинжилгээний аргыг хослуулан ашиглаж, дэлхийд болон Монгол улсад тэргүүлж буй мэдээллийн найман сайтыг эргэлтэнд оруулж буй мэдээллийн чанар болон дэлхий даяар үйл ажиллагаа явуулж буй сайтуудын рейтингийг хандалт, хэрэглэгчдийн тоон дээр үндэслэн гаргадаг www.alexa.com сайтыг эрэмбэлэлд үндэслэн сонгов. Үүнд:

- <https://www.nytimes.com/>,
- <https://www.cnn.com/>,

- <http://www.bbc.com/news>,
- <http://www.foxnews.com/>,
- www.news.mn,
- www.eagle.mn,
- www.gogo.mn,
- www.ikon.mn юм.

Дээрх сайтуудын 2018 оны 04 сарын 09-өөс 15-ны өдрийг дуустал нэг долоо хоногийн хугацаанд эргэлтэнд оруулсан 997 мэдээ, мэдээллийг судалгааны эх хэрэглэгдэхүүнээр түүвэрлэн авч гүйцэтгэв. Ингэхдээ тухайн мэдээллийн сайтын өөрийн архивыг болон нийгмийн сүлжээн дэх тухайн сайтын албан ёсны хуудсыг эх сурвалж болгов. Энд үйл явдлыг шуурхай мэдээлэх зорилгоор цуврал хэлбэрээр эргэлтэнд орсон мэдээг нэг багц болгосон тухайн редакцийн тойм мэдээг сонгосныг дурдах нь зүйн хэрэг. Мөн тухай мэдээллийн сайтын үндсэн хэсэгт нийтлэгдсэн мэдээллийг судалгааны эх хэрэглэгдэхүүнээр сонгосон болно.

Судалгааны үр дүн. Агуулгын ерөнхий шинжилгээг өнгөц байдлаар мэдээ мэдээллийн сэдвээр хийсэн бөгөөд ингэхдээ улс-төр, эдийн засаг, урлаг, спорт, байгаль экологи, бусад гэсэн ерөнхий байдлаар ангилж үзэв. (Хүснэгт 01) Судалгааны чиглэл тэмдэгтэд төвлөрч хийгдсэн учир агуулгын энэхүү ангилалд онцгой ач холбогдол өгөөгүйг дурдах нь зүйтэй болов уу. Судалгааны эх хэрэглэгдэхүүнийг түүвэрлэх хугацааны олон улсын болон Монгол Улсын дотоодын байдал харьцангуй тогтвортой байв. Улс төрийн сэдэвт мэдээ, мэдээлэл дийлэнх буюу 30% байсан бол бусад сэдвийн мэдээлэл 6-7%-ийн жигд тархалттай байгаа нь ажиглагдаж байна. (Хүснэгт 01)

	Сэдэв	Дотоодын Гадаадын Нийт		
1.	Эдийн засаг	60	9	69
2.	Спорт	45	16	61
3.	Урлаг	12	34	46
4.	Улс төр	165	107	272
5.	Байгаль экологи	52	80	132
6.	Бусад	320	97	417
	<i>Нийт</i>	654	343	997

Хүснэгт 01. Сэдвийн ангилал

Тухайн мэдээ, мэдээлэлд ашигласан тэмдэгтийн хэлбэрүүдээр нь:

- Эх бичвэр
- Гэрэл зураг
- Хөдөлгөөнт дүрслэл /видео/

- Дуу авиа /аудио/
- Хүснэгт /график/ зэргээр ангилж харьцуулан судаллаа. (Хүснэгт 02)

	Тэмдэгтийн зурвас	Дотоодын	Гадаадын
1.	Эх бичвэр(мэдээнд ашигласан үгийн дундаж тоо)	354.4	751.5
2.	Гэрэл зураг	1629	724
3.	Видео	53	236
4.	Аудио	1	2
5.	Хүснэгт/ график	22	8

Хүснэгт 02. Тэмдэгтийн тархалтын байдал

Эх бичвэр: Цахим нийтлэлийн “гол багана” болох эх бичвэрийн ашиглалт эрс ялгаатай байна. Монголын мэдээллийн сайтуудийн мэдээ мэдээлэл дэх эх бичвэр гадны мэдээллийн сайтуудынхаас хоёр дахин бага буюу 300-400 үгтэй байгаа нь ажиглагдав. Хамгийн их эх бичвэртэй мэдээ нь www.eagle.mn сайтын эдийн засгийн сэдэвтэй мэдээ байсан ба 5391 үг ашигласан харин гадны мэдээллийн сайтуудын мэдээ хамгийн ихдээ 3000 орчим үгтэйн дээр нийт мэдээний дийлэнхэд нь буюу 74%-д 700-800 орчим үг ашиглажээ.

Гэрэл зураг: Монголын мэдээллийн сайтууд нэг мэдээнд дунджаар 2,5 ширхэг зураг ашиглаж байгаа бол гадаад нэг мэдээнд дунджаар 2,08 ширхэг зураг ашиглаж байна. Эл элементийн ашиглалт харьцангуй өртөг багатай тул нийт эх хэрэглэгдэхүүний 90% орчим нь ашигласан байна.

Хөдөлгөөнт дүрслэл /видео/: Тухайн сайтад нийтлэгдсэн мэдээллийн видео агуулгыг редакци өөрөө бүтээсэн эсвэл гаднаас ашиглаж байгаа эсэхээр нь ангилаад, улмаар редакцийн өөрийн бүтээсэн видео агуулгыг эх хэрэглэгдэхүүнээр авав.

Нийт мэдээний 28,9% (289) нь эл тэмдэгтийг ашигласан бөгөөд үүний дийлэнх нь гадны мэдээллийн сайтуудынх байв. Судалгаагаар гадны мэдээллийн сайтуудын мэдээллийн 68,8% нь видео хавсрагатай байсан бол, монголын мэдээллийн сайтуудын мэдээллийн ердөө 8,1% нь л видеотой байна.

Холбоос: “Интернет мэдээлэл нь хэрэглээний холбоос бүхий хайлтын таатай орчин; хийбэр бичиглэлийн орчны нэгдмэл, тасралтгүй бодит байдал; мэдээлэл хүртэх нээлттэй байдал; харилцаа, илэрхийллийн чөлөөт байдал эдгээрийг хангаж байна”⁵, иймд эл судалгаанд эх хэрэглэгдэхүүний холбоост байдлыг нэг элементийн түвшинд авч үзэн шинжлэв. Дотоодийн мэдээллийн сайтуудын мэдээлэл дунджаар 27%, гадаад

мэдээллийн сайтуудын мэдээлэл дундажаар 80% нь тухайн мэдээлэлд холбогдох бусад мэдээлэлрүү хөтлөх холбоосыг хавсаргасан байна.

Аудио: Хэрэглэгчийг ятгах хамгийн хүчтэй элментийн нэг яах аргагүй аудио мөн. Тус элементийн хэрэглээ судлагдсан обектод тун бага буюу гурван мэдээнд л ажиглагдав. Үүний хоёр нь www.cnn.com сайтынх, нэг нь www.gogo.mn сайтын мэдээлэл байв.

График: Графикийн элементийг интерактив байдлаар буюу инфографикаар тоон мэдээлэлд түлхүү ашиглагддаг. Судалгаагаар дотоодын мэдээллийн сайтуудыг эл элементээр www.ikon.mn сайт тэргүүлж байна. Нийт графикийн элемент ашигласан дотоодын мэдээллийн сайтуудын мэдээллийн 50%-д хүрч байна.

Сэдвийн ангилал	Эдийн засаг	Спорт	Урлаг	Улс төр	Бусад
www.gogo.mn					
Зураг	14	6	2	18	87
Видео	1	1	1	0	14
График	2	0	0	1	1
Аудио	0	0	0	0	1
Хүснэгт	1	0	0	0	2
Холбоос 2+	35	1	0	4	28
www.ikon.mn					
Зураг	22	6	2	57	133
Видео	3	0	0	7	7
График	3	0	0	0	3
Аудио	0	0	0	0	0
Хүснэгт	4	0	0	1	5
Холбоос 2+	14	3	2	33	78
www.eagle.mn					
Зураг	14	29	3	57	107
Видео	0	1	0	1	6
График	2	0	0	1	0
Аудио	0	0	0	0	0
Хүснэгт	3	0	0	1	1
Холбоос 3+	8	17	3	31	59

www.news.mn

Зураг	9	3	4	30	38
Видео	1	0	2	1	2
График	0	0	0	0	0
Аудио	0	0	0	0	0
Хүснэгт	0	0	0	0	0
Холбоос 4+	1	0	4	5	6

www.foxnews.com

Зураг	0	0	4	25	61
Видео	0	0	3	22	33
График	0	0	0	0	0
Аудио	0	0	0	0	0
Хүснэгт	0	0	0	0	0
Холбоос 6+	0	0	3	22	53

www.cnn.com

Зураг	0	8	14	59	29
Видео	0	6	12	43	23
График	0	0	0	1	1
Аудио	0	0	0	1	1
Хүснэгт	0	0	0	1	2
Холбоос 4+	0	6	11	41	28

www.bbc.com/news

Зураг	6	1	7	9	48
Видео	0	1	1	6	15
График	3	0	0	0	0
Аудио	0	0	0	0	0
Хүснэгт	1	0	0	0	0
Холбоос 6+	5	1	5	8	38

www.nytimes.com

Зураг	2	6	8	13	38
Видео	0	2	1	0	2
График	0	0	0	0	0
Аудио	0	0	0	0	0
Хүснэгт	0	0	0	0	0
Холбоос 4+	2	4	6	4	12

Хүснэгт 03. Мэдээний сэдэв хийгээд тэмдэгтийн ашиглалт

Мэдээний сэдэв хийгээд тэмдэгтийн ашиглалт хамаарал: Монголын мэдээллийн сайтын улс төрийн мэдээ эх бичвэр, зураг зонхилсон бөгөөд бусад элементүүд болох видео, график, хүснэгтийг маш бага ашиглаж байна. Харин гадаадын мэдээллийн сайтын улс төрийн мэдээ нь эх бичвэр, зураг, видеог хослуулж түгээмэл

хэрэглэж байна. (Хүснэгт 03). Эдийн засгийн мэдээллийг хүлээн авагчидад хүргэхдээ тоон үзүүлэлтийг ойлгомжтойгоор буюу дундаж уншигчид ойлгомжтой хэлбэрээр хүргэх нь чухал байдаг. Гэтэл Монголын мэдээллийн сайтын эдийн засгийн мэдээнд эх бичвэр, зураг зонхилсон, дундаж уншигчид ойлгомж багатай мэдээлжээ.

Дүгнэлт. Энэхүү ажлаар Монголын мэдээллийн сайтууд бэлдэж буй мэдээллээ хэрэглэгчдийн мэдээлэл хүлээн авах зан төлвийн шинэ чиг хандалгад хэрхэн нийцүүлэн бэлтгэж буйг дэлхийд тэргүүлэх мэдээллийн сайтуудын бэлтгэн эргэлтэд оруулж буй мэдээлэлтэй харьцуулан судлахыг зорьсон.

Мультимедиа элементийн ашиглалтын харьцуулсан судалгаагаар аль ч сэдвээр эргэлтэнд орсон мэдээллийн эх бичвэрт агуулагдах үгийн тоо эрс ялгаатай байна. Тухайлбал Монголын мэдээллийн сайтуудын мэдээ мэдээлэл дэх эх бичвэр гадны мэдээллийн сайтуудынхаас хоёр дахин бага байгаа нь харагдаж байна. Энд мэдээж зорилтот хэрэглэгчийн мэдээлэл хүлээн авах зан төлөв, сэтгүүл зүйн мэргэжлийн байгууллагын уламжлал гээд олон хүчин зүйлийн нөлөө бий юм.

Мөн орчин цагийн хэрэглэгчдийн эрхэмлэх болсон видео элементийн ашиглалт хэт зөрөөтэй байгаа нь судалгаагаар ажиглагдаж байна. Тодруулбал, Монголын мэдээллийн сайтуудын видео элементийн ашиглалт гадны сайтуудаас 8,5 дахин бага байна. Видео элементийг бүтээх өртөг харьцангуй өндөртөйд тооцогддог. Магадгүй энэ шалтгаанаар Монголын мэдээллийн сайтуудын эргэлтэд оруулж буй мэдээ мэдээлэлд энэ элемент дутмаг байгаа болов уу.

Манай сайтууд зөвхөн эх бичвэр, зургийн хослолоор нийт мэдээллийнхээ 90% гаруй бэлдэж байна. Энэ нь мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ, тэдний давтан сургалт зэрэг олон хүчин зүйлийн шалтгаантайг дурдах нь зүй.

Олон сэдвээр чанаргүй олон мэдээ нийтэлж байна. Гадаадын

мэдээллийн сайтууд мультимедиа элементийг илүү өргөн хэрэглэж чанартай цөөхөн мэдээллийг хүргэж байна.

Тэмдэгтийн олон төрлийн зохист харьцааг хадгалж мэдээллээ бэлдэх нь өнөөдрийн Монголын редакциудын нэн тэргүүнд анхаарах зүйл болсон нь дамжиггүй. Нэн ялангуяа видео элементийн ашиглалтад анхаарч ажиллах нь хэрэглэгчдийнхээ эрэлт хэрэгцээг тодорхой хэмжээнд хангах юм.

Ишлэл

- ¹ Global Digital Report. 2018
- ² Б.Болд-Эрдэнэ “Нийгэм, Интернет, Сэтгүүлзүй”. Улаанбаатар. 2017.х.98
- ³ Роберт, Л.Фрийдман, Дэлхий хавтгай., - NY, 2005, х.22
- ⁴ Б.Болд-Эрдэнэ “Нийгэм, Интернет, Сэтгүүл зүй”. Улаанбаатар. 2017.х.100
- ⁵ Б.Болд-Эрдэнэ “Нийгэм, Интернет, Сэтгүүл зүй”. Улаанбаатар. 2017.х.39

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Б.Болд-Эрдэнэ “Нийгэм, Интернет, Сэтгүүлзүй”
2. Б.Болд-Эрдэнэ “Интернет Сэтгүүл зүй”. 2009.
3. Роберт, Л.Фрийдман, Дэлхий хавтгай., - NY, 2005
4. Кастельс.М “Галактика интернет”. 2004
5. Paul.N Fiebich “The Elements of digital storytelling”. 2015

Abstract

Multimedia had known as one of the key aspect in digital reporting. Following study is aiming to differentiate the multimedia elements usage between world-leading online news and local. Within the framework of one week's circulation. Study conducted on 997 news. As a result of content analyzes: local news's video elements are 8.5 times less than world-leading news in number and duration. And vast majority of online news from local sites have 2 times less body-text than another. As a post-soviet country, Mongolia has its own attribute in journalism.